

УЦУОШТ-ИЙН ДАРГА

БАТЛАВ

А.ЭНХЗАЯА

УЦУОШТ-ИЙН АЛБАН ХААГЧДАД АЖЛЫН ҮР ДҮНГИЙН
УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

2024-01-13

1. Нийтлэг үндэслэл

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 442 дугаар тогтоолоор Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь заалтын 40% гэснийг 50% гэж өөрчилсөн, Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.6 дахь заалт, байгууллагын дотоод журмыг үндэслэн төвийн салбар нэгжид ажиллаж байгаа нийт албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход энэхүү журмыг баримтална.

2. Зорилго

Салбар нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчийн ажил гүйцэтгэх чадвар, мэргэжлийн түвшинг дээшлүүлэх бүтээлч санаачлага өндөр үр дүнтэй ажиллах сонирхолыг нэмэгдүүлэх зорилгоор улирлын ажлын үр дүнгээр тооцон мөнгөн урамшуулал олгоход оршино.

3. Олгох хугацаа

Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй, холбогдох дээд шатны байгууллагын удирдлаас өгсөн үүрэг даалгавар бүрэн биелүүлсэн зэргийг харгалзан албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүйгээр олгоно.

4. Шалгуур үзүүлэлт

Төвийн албан хаагчид:

1. Тухайн салбар нэгж нь шинжилгээ мэдээлэл үйлчилгээний ажлын дүнгээрээ улсад 1-5 байр эзэлсэн буюу урд оны ажлын үзүүлэлтээс 1-ээс дээш байраар ахисан байна.
/төсвөөс хамаарна/ -50 оноо
 - 1 дүгээр байр-50 оноо
 - 2 дугаар байр-47 оноо
 - 3 дугаар байр-45 оноо
 - 4 дүгээр байр-42 оноо
 - 5 дугаар байр-40 оноо

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмыг мөрдөн ажилласан байх ба аливаа нэгэн сахилгын шийтгэл аваагүй байна. -5 оноо
3. Ус, цаг уур орчны хяналт- шинжилгээний ажлын технологийн сахилгын зөрчил, өөрийн буруугаас шалтгаалсан багаж тоног төхөөрөмжийн гэмтэл гаргаагүй байх-5 оноо
4. Тухайн инженертэй холбоотой ямар нэгэн санал гомдол ирээгүй байна.-5 оноо
5. Ажлын цаг ашиглалт, олон нийтийн ажилд оролцсон байдал, зохион байгуулсан ажил таслаагүй байна. -10 оноо
6. Мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх талаар санаачлагатай ажилласан байна.-5 оноо
7. Судалгаа шинжилгээний ажил хийсэн байна.-10 оноо
8. Шинэ бүтээлч санаа ажилдаа ашигласан байдал /өөрийн салбарын чиглэлийн загвар, програм, сайтын мэдээ мэдээлэл, өөрийн ажилдаа туршиж ашигласан/ -5 оноо
9. Холбогдох дээд шатны байгууллагын удирдах албан тушаалтан /газар, хүрээлэнгийн холбогдох хэлтсийн дарга, хүрээлэнгийн салбар хариуцсан инженер, төвийн дарга, хэлтсийн дарга, инженер/-ээс өгсөн үүрэг даалгаврыг хэрхэн биелүүлсэн байдал.-5 оноо

5. Үр дүнгийн урамшуулал олгох хувь

Ажлын дүгнэж авсан оноо	Үр чадвар олгох хувь
98.0-100	50%
95.0-97.9	40%
90.0-94.9	30%
85.0-89.9	20%
80.0-84.9	10%

Жич: Салбар нэгжийн төвөөс ирсэн дүнгээр эхний 1-5 байранд орсон буюу өмнөх оноос ажлын үзүүлэлт 3-с дээш байраар ахиулж ажилласан албан хаагчийн ажлыг харгалзан үзэж тус журмын шалгуур үзүүлэлтээр төвийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцээд дээрх үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох хувийг төвийн даргын зөвлөл тогтооно.

УЦУОШТ-ИЙН ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛ

УЦУОШТ-ИЙН ДАРГА

БАТЛАВ

А.ЭНХЗАЯА

УЦУОШТ-ИЙН САЛБАР НЭГЖҮҮДЭД АЖИЛДАГ АЖИЛЧДЫН
АЖЛЫН ҮР ДҮНГИЙН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

2024-01-13

1. Нийтлэг үндэслэл

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 442 дугаар тогтоолоор Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь заалтын 40% гэснийг 50% гэж өөрчилсөн, Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.6 дахь заалт, байгууллагын дотоод журмыг үндэслэн төвийн салбар нэгжид ажиллаж байгаа нийт албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход энэхүү журмыг баримтална.

2. Зорилго

Орон нутгийн салбар нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчийн ажил гүйцэтгэх чадвар, мэргэжлийн түвшинг дээшлүүлэх бүтээлч санаачлага гаргаж, үр дүнтэй ажиллах сонирхолыг нэмэгдүүлэх зорилгоор улирлын ажлын үр дүнгээр тооцон мөнгөн урамшуулал олгоход оршино.

3. Олгох хугацаа

Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй, холбогдох дээд шатны байгууллагын удирдлаас өгсөн үүрэг даалгавар бүрэн биелүүлсэн зэргийг харгалзан албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүйгээр олгоно.

4. Шалгуур үзүүлэлт

Орон нутагт ажиллаж байгаа албан хаагчид:

1. Орон нутагт ажиллаж байгаа цаг уурын өртөө, харуул, ус судлалын харуулуудад ажиллаж байгаа албан хаагчдын ажлын үр дүнгийн урамшууллыг шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын дүнгээрээ төвдөө 1-5 байр эзэлсэн байна. /төсвөөс хамаарна/ - 50 оноо
 - 1 дүгээр байр-50 оноо
 - 2 дугаар байр-47 оноо
 - 3 дугаар байр-45 оноо

4 дүгээр байр-42 оноо

5 дугаар байр-40 оноо

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмыг мөрдөн ажилласан байх ба аливаа нэгэн сахилгын шийтгэл аваагүй байна. -5 оноо
3. Ус, цаг уур орчны хяналт- шинжилгээний ажлын технологийн сахилгын зөрчил, өөрийн буруугаас шалтгаалсан багаж тоног төхөөрөмжийн гэмтэл гаргаагүй байх-5 оноо
4. Тухайн салбар нэгжтэй болон тэнд ажилладаг албан хаагчтай холбоотой ямар нэгэн санал гомдол ирээгүй байна.-2 оноо
5. Ажлын цаг ашиглалтыг бүрэн ашиглах, шуурхай мэдээлийг таслаагүй бүрэн дамжуулсан.-10 оноо
6. Мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх талаар санаачлагатай ажилласан байна.-5 оноо
7. Сум орон нутагтайгаа хамтран ажилласан байх.-10 оноо
8. Шинэ бүтээлч санаа ажилдаа ашигласан байдал -3 оноо
9. Холбогдох дээд шатны байгууллагын удирдах албан тушаалтан /төвийн дарга, хэлтсийн дарга, төвийн салбар хариуцсан инженер, ахлах техникч нар/-аас өгсөн үүрэг даалгаврыг хэрхэн биелүүлсэн байдал.-5 оноо
10. Орон нутагтаа төвөөс гаргаж байгаа цаг агаарын урьдчилсан болон бусад бүх төрлийн мэдээ мэдээллээр тогтмол үйлчилсэн байх /төвийн салбаруудаас гаргаж байгаа цаг агаарын 10 хоног, сар, улирал, анхааруулга, сэрэмжлүүлэг, бэлчээрийн даац, зудын эрсдэл, гол усны гэх мэт/ -5 оноо

5. Үр дүнгийн урамшуулал олгох хувь

Ажлын дүгнэж авсан оноо	Ур чадвар олгох хувь
98.0-100	50%
95.0-97.9	40%
90.0-94.9	30%
85.0-89.9	20%
80.0-84.9	10%

Жич: Хөдөө орон нутгийн салбар нэгжүүдэд ажиллаж байгаа ажилчдыг төвийн салбаруудаас гаргасан дүнгээр эхний 1-5 байранд орсон буюу, шуурхай мэдээний тасалдал /урирал, жилд/ гаргаагүй албан хаагчийг тус журмын шалгуур үзүүлэлтээр төвийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцээд дээрх үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох хувийг төвийн даргын зөвлөл тогтооно.

УЦУОШТ-ИЙН ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛ